

БНХАУ-ЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Бүх нийтийн төлөө

Дээд боловсролын хөгжлийн бүтцийн цар хүрээнээс харахад дэлхийн дээд боловсролын хөгжил нь нарийн, бүх нийтийн, түгээмэл хэлбэрийн гэсэн 3 үе шаттай. Одоогийн байдлаар дэлхийн улс орны дээд боловсрол бүх нийтийн журам руу оржээ. Тухайлбал, АНУ-д их дээд сургуульд суралцагчдын тоо 50%-аас давж түгээмэл шатанд хүрсэн. Хятад улсад 1990 оноос хойш дээд боловсрол хурдацтай хөгжиж, 1999 онд дээд сургуулиуд цар хүрээгээ өргөжүүлж, дээд боловсрол хурдацтай хөгжлийн үед дэвшин орсон юм.

Нийгмийн цогц хөгжлийн зэрэгцээ бодит байдлаас харахад дээд боловсролыг бүх нийтээр эзэмшиж эхэлсэн. Энэ нь тоо хэмжээгээр өргөжсөн төдийгүй бүхэл бүтэн дээд боловсролын цогц чанар болж хувирав. Шинэчлэлийн явц хөгжихийн хамт ард түмний амьдралын түвшин сайжирч, тус орны дээд боловсрол нарийнаас бүх нийтийн хэлбэрт шилжсэн учраас ирэх 10 жил, энэхүү хувирал өөрчлөлтийн зангилаа үе юм.

Их сургуулийн ирээдүй

Шинэчлэлийн явц их сургуулийг нийгэм эдийн засгийн хүрээнээс ирээдүйн хөгжилд хөтлөнө. Хүн төрөлхтөн XXI зуунд орсон цаг үед ШУ боловсрол, нийгэм эдийн засаг дахь стратегийн байршлаа дагаад XX зууны эцэст хөгжсөн нь мэдээллийн, генийн, сүлжээний зэрэг техникт өдөр ирэх тутам тод харагдаж байна.

Оюуны болон ШУ-ны эрэл хайгуул хийх нь цаг үеийн гол хөг юм. Боловсролгүйгээр оюуны эрэл хайгуул хийнэ гэж ярихын ч хэрэггүй.

Оюуны эдийн засгийг угтсан өрсөлдөөнтэй цаг үе болох орчин үе төдийгүй, аж үйлдвэр, эдийн засгаас оюуны эдийн засагт шилжих ирээдүйд боловсрол ялангуяа дээд боловсрол, нийгэм эдийн засгийн төвшин дэх гол оролцоо юм. Боловсрол, үйлдвэрийн хүчин чадлыг улам сайжруулах төдийгүй эдийн засгийн арвин их үр өгөөж авчирч суурь аж үйлдвэрийн хөгжлийг хурдасгана.

Түүний байршил, үүрэг, чадварыг урьдынхтай харьцуулшгүй юм. Их сургуулийн чадвар нь хүнийг хүмүүжүүлэх үнэ цэнээр илэрдэг төдийгүй, ялангуяа эрдэм шинжилгээний болон нийгмийн үйлчилгээний үнэ цэнээр илүү их илэрдэг.

Хятадын их сургуулийн тоо, чанар, түвшин болон бодит хүчин чадлын ирээдүйн хөгжил 21-р зуунд улсынхаа хүчийг нэгтгэх өрсөлдөөний гол хүчин зүйл бөгөөд тэр ч байтугай тэр хүчин зүйлийг шийдвэрлэнэ.

Их сургуулийн цогц онцлог

Их сургуулийн цогц онцлог 2 янзаар илэрдэг. Үүнд:

1-рт, Бэлтгэх төслийн цогц.

2-рт, ШУ-ны салбарын цогц.

Их сургууль нийгэмд ирээдүйн гол боловсон хүчин бэлтгэдэг боловсролын түшиц газар бөгөөд цогцолбор ШУ-ны салбар байж байгаль, үйлдвэр, соёлын олон төрлийн ШУ-ны салбартай ажиллаж байна. Тийм байж л сая өргөн уудам ШУ соёлын хөгжилд ирээдүйн нийгмийн гол боловсон хүчинг бүх талаар сурган бэлтгэж гаргана. Хятад улсын засгийн газар 90-ээд онд XXI зуунд хандсан сургалтын агуулгын хичээлийн бүтэц судалгааг гол болгон сургалтын өөрчлөлтийг эхэлсэн бөгөөд хожмын их үр өгөөж, дээд сургуулийн удирдлагын тогтолцоог өөрчилж, дээд боловсролын цогц асуудлыг сайжруулсан.

Их сургуулийн шинж хандлага

Сүлжээ, мэдээллийн болон дэлхийн эдийн засгийн цогц хурдацыг дагаад Хятад ДХБ-д элсэж, эдийн засаг, соёл, боловсролын өргөн хүрээнд олон улстай харилцах хамтын ажиллагаа өдөр ирэх тусам цэцэглэн хөгжиж байна. Хятадын дээд боловсрол улам дэлгэрэн олон улсын шинжтэй болж, гадаад хүмүүс хойно хойноосоо “цувран ирцгээж” улс дамнасан сургалттай болсон байна.

Сургалтыг шууд хийхийн зэрэгцээ интернетээр дамжуулан “зайны сургалт”-тай болж гадаадад суралцах хүний тоо их хэмжээгээр нэмэгдэнэ. Мэдээллийн техник хөгжсөнөөр мэдлэг хүртээх хэрэгсэл улс дотроо хязгаарлагдахгүй олон оронд дамжин, мэдээллийг өргөн дэлгэр мэдэж сонсож байна.

Дээд боловсрол олон улсын шинжтэй, олон орны дээд боловсролын хөгжлийн стратегийн нэгэн зорилго болсон.

Үйлдвэрлэл, сургалт, судалгааны цогц хандлага

Өнөөгийн нийгэмд үйлдвэрлэл, сургалт, судалгааны хамтын ажиллагаа дээд боловсролын хөгжлийн гол агуулга болсон.

Боловсрол, үйлдвэрлэл нь ЗГ болон бусад олон хүрээний анхаарлыг татаж, үйлдвэрлэл, сургалт, судалгааны хамтын ажиллагааг нийтээр мэдэх болсон. XXI зууны нийгэм эдийн засаг, ШУ техник XXI зууны их сургуулийн хөгжлийг шийдвэрлэх төдийгүй хөтлөнө.

Үүний зэрэгцээ XXI зууны их сургууль, нийгэм эдийн засаг болон ШУ техникийн хөгжил дэвшилд дагуулж тус дөхөм үзүүлнэ. Энэ нягт харилцаа холбоо, нэг талаас их сургуулиуд боловсон хүчин бэлтгэх, оюуны хувь нэмэр оруулах, ШУ-ыг дэлгэрүүлэх, ШУ-ны ололтыг аж үйлдвэржүүлэх замаар нийгэм эдийн засгийг сайжруулахад илэрдэг.

Нөгөө талаас XXI зууны их сургууль үйлдвэрлэл, сургалт, судалгааны нэгэн цогц боловсон хүчний хэлхээ болж, үйлдвэрлэл сургалт судалгаа, их сургуулийн хөгжил болон боловсон хүчинг бэлтгэх хөдөлгөгч хүч юм. Боловсон хүчин бэлтгэх нь аж үйлдвэрийн байгууллага болон олон нийтийн байгууллага сургуультай хамтран бэлтгэх хэлбэр бөгөөд бодитоор илрэхдээ:

Боловсрол, үйлдвэрлэл, шинжилгээ, судалгаа З-ыг хослуулахыг чухалчилж, хичээлийн зорилго бүтэц бий болгох, хүмүүжлийн хэлбэрийг нийгмийн хөгжлийн хэрэгцээнд тохируулан зохицуулалт хийж, эрдмийн зэрэг горилох бүтээлийн хэрэглээний ерттийг баримталдаг.

Өвөрмөц чанар, бүтээлч хүч чухал

Орчин үеийн боловсролын үнэ цэнэ, оюутныг өвөрмөц чанартай, чөлөөтэй, төгс боловсролтой болгоход зайлшгүй анхаарах ёстойг шаардана. Оюутны цогц бүтээлч шинжийг бий болговол үндэстний хөгжлийн хөдөлгөгч хүчин юм.

Боловсролын зорилго нь оюутны олон ишт соёл болон үнэ цэнэтэй тулгарахад бие даан магадлах, сонгох, шүүмжлэх оюуны чадвартай болгоход чиглэнэ. Чухамдаа бүтээлч хүч гэдэг өвөрмөц чанараас үүсэн гарсан ухагдахуун бөгөөд оюутны өвөрмөц чанарыг бий болговол өргөн харилцаанд тэдний бие дааж ойлгох, шинийг эрэлхийлэх чадварыг хөгжүүлэх юм.

Нарийн дараалалтай аспирантын боловсролын хувьд бүтээлч хүчийг бий болговол бүр ч чухал. Өвөрмөц чанар, бүтээлч хүч бий болохыг чухалчилвал хүнийг бүх талаар хөгжүүлэхийн хамгийн чухал үндэс юм.

*Аньхуйгийн их сургуулийн их дээд сургуулийн судалгааны
төвийн эрдэм шинжилгээний бичиг. 2004 он*

*Хятад хэлнээс орчуулсан Ч.Таамаа /МУИС,
Гадаад хэл соёлын сургууль, доктор/*